

**ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<b>Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.</b>							
<i>“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</i>							
1.1.1.	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой		Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 244 Аж нэгж, байгууллагад сургалт хийж нийт 19630 иргэд, даатгуулагч хамрагдсан байна. Мөн албан хаагчдад хуулийн шинэчлэлийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэхээр гаргасан 100 гаруй дүрэм, журам, зааврыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллаж байна. Мөн дээд шатны байгууллагаас ирүүлсэн хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд шаардлагатай заавар, чиглэлийг төвийн болон сумдын байцаагч нарт тухай бүр танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд тус газар нь өөрийн цахим хуудас <a href="http://www.hentii.ndaatgal.mn">www.hentii.ndaatgal.mn</a> вэб сайт, <a href="https://www.facebook.com/NDKHenti">www.facebook.com/NDKHenti</a> фэйсбүүк, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар” фэйж хуудсаар 111 мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГгазраас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 256 мянга гаруй	

	<p>шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>Шаард- лагагүй</p>		<p>хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.</p>		<p>иргэд даатгуулагчдад хүрсэн байна. Сайн дурын даатгуулагчдад зориулсан “Та шимтгэлээ төлсөн үү” гэх ерөнхий орлогын мэдээлэлтэй, шимтгэл төлөх заавартай постерийг сар бүр цахим орчинд байршуулж хэвшсэн. Зүрхэн нутгийн дуу хоолой ТББ-н дэргэдэх “Аруухан” фейж хуудастай 2024 онд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээний дагуу 2 шторк, 6 мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэн ажилласан. Нээлттэй мэдээллийн сарын хүрээнд</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль</li> <li>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль</li> <li>- Сайн дурын даатгалын талаар 3 удаагийн live дамжуулалт хийж хийт 36 мянган хүний хандалт авсан байна. Мөн “Мэдлэгтэй чихэр” Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн тухай контентыг бэлтгэн цахим орчинд байршуулснаар 2,7 мянган хүний хандалт авсан.</li> </ul> <p>Цахим хуудас болон албан хаагчдыг идэвхижүүлэх зорилгоор “Бурмаар тэтгэхээр, Урмаар тэтгэ”, “Дэм дэмэндээ” зэрэг контентуудыг хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>Хэнтий аймгийн төв Хэрлэн сумын багууд, олон нийтийн хөдөлгөөн ихтэй гудамж талбай, Хүнс барааны дэлгүүрүүд, зах худалдааны төв, арилжааны банкуудад явуулын үйлчилгээ 2 удаагийн давтамжтай зохион байгуулсан. Мөн Хэнтий аймгийн ЗДТГазартай хамтран 18 сумдад нийт 47 удаагийн “Явуулын үйлчилгээ”-г зохион байгуулж 2311 иргэд даатгуулагчид хамрагдсан байна.</p> <p>Мөн “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд Ажил олгогчдын сургалт зохион байгуулж,</p>	<p>100</p>
--	--	---------------------------	--	---	--	---	------------

						сумдын аж ахуйн нэгж байгууллагад 3 удаагийн Zoom уулзалтаар давхардсан тоогоор 315 ажил олгогчийн нягтлан бодогчдод сургалт хийсэн байна.	
1.1.2.	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.	Шаардлагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо	2023 онд 851 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 400 малчин шинээр хамруулав.	Сайн дурын даатгалд 2024 онд 680 даатгуулагч, үүнээс 207 малчин даатгуулагчийг шинээр хамруулж, хамралтын төлөвлөгөөг биелүүлсэн байна.	2024 оны байдлаар Хэнтий аймгийн хэмжээнд нийт <b>4969</b> иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна. Үүнээс <b>835</b> даатгуулагч шинээр хамрагдсан. Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт <b>2286</b> бөгөөд шинээр <b>486</b> малчин хамрагдсан. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт <b>876</b> даатгуулагч хамрагдсанаас шинээр <b>63</b> даатгуулагч хамрагдсан. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 46 эцэг, эхийг даатгалд шинээр хамруулаад байна. “2024 оныг нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай” А/61 дүгээр тушаал, “Болзолт уралдаан зарлах тухай” А/79 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд нийгмийн даатгалд шинээр хамруулах сайн дураар даатгуулагчдийн тооны төлөвлөгөөг биелүүлэх хамрагдалтыг нэмэгдүүлэх хэрэгжилтийг ханган ажиллах талаар олон талт арга хэмжээ авч ажиллаа. Үүнд иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, аймаг сумын халамжийн газартай хамтран ажиллаж 0-18 насны хбх асарч байгаа эцэг эхийн судалгаа, мөн 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн судалгаа авч тэдгээрийг нийгмийн даатгалд сайн дураар хамруулах ажлыг зохион байгууллаа. Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа иргэдийн жагсаалтаас мэдээлэл авч	100

						<p>холбогдон сайн дурын даатгалын ач холбогдлын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, сайн дурын даатгалд хамруулсан. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилах чиглэлээр “Малчидын зөвлөгөөн”-д оролцож Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлсэн найруулга, болзолт уралдааны талаар, малчны сайн дурын даатгалын талаар сургалт хийж, зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. Эвт худалдааны төвийн түрээслэгч нарт сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, гарын авлага тараасан. ХБХ асарч байгаа эцэг, эхийн даатгал, Малчны сайн дурын даатгалын ач холбогдолын талаар сайн дурын даатгалд хамрагдхад уриалсан видео контент бэлгэж газрын фэйж хуудсаар нийтлэсэн. Газрын фэйж хуудсаар сайн дурын даатгалын талаар лайв хийж мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Мөн багийн дарга нартай хамтран ажиллаж хамрагдвал зохих малчдын судалгааг гаргаж малчдыг малчны сайн дурын даатгалд хамруулах зэрэг ажлыг зохион байгуулсан.</p>	
1.1.3.	<p>Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх.</p>	Шаардлагагүй	<p>Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо</p>	<p>2023 онд 78 ажил олгогч, 283 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав.</p>	<p>Ажил олгогчийн тоог 71, даатгуулагчийн тоог 292 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.</p>	<p>Аймгийн Улсын бүртгэлийн газар, Татварын газартай хамтран шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд үндэслэн албан журмын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх чиглэлийг сумдын байцаагчдад өгсөн. Үйл ажиллагаа явуулдаг боловч нийгмийн даатгалд хамрагдаагүй 12 ажил олгогчийг илрүүлж, тайлан тооцоог хийсэн.</p> <p>2024 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр <b>89</b> ажил олгогчийн 286 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан байна.</p>	90
<p><b>Биелэлт – 290 / 3      96,6 %</b></p>							

**Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт**

*“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*

2.1.1.	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах.	Шаардлагагүй	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл	Нийгмийн даатгалын санд 2023 онд 49524,6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 92147,0 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	2024 онд нийгмийн даатгалын сангийн орлого 58793,5 сая төг, зарлагын гүйцэтгэл 126253,6 сая төгрөгөөр тус тус төсвийн хуваарь батлагдсанаас сангийн орлого 58898,9 сая төгрөг буюу 100,2 хувийн гүйцэтгэлтэй, зарлага 126253,6 сая төгрөг буюу 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.	100
2.1.2.	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах.	Шаардлагагүй	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл	Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1288,7 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	а) Байгууллагын үйл ажиллагааны зардалд 1,548.82 сая төгрөг батлагдсанаас цалин хөлсөнд 1,103.15 сая төгрөг нийгмийн даатгалын шимтгэлд 139.40 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.46 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.84 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5.89 сая төгрөгийг, эдийн засгийн ангилал зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, 6 орон тоо дутуу байгаатай холбоотой цалин сан хэмнэгдсэн. б) Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТатварыг тухай бүр шилжүүлж өглөг авлага үүсгэлгүй ажилласан болно. в) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн зардал тус бүрийг хэтрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан ажил үйлчилгээг явуулсан ба одоогийн байдлаар 2024 онд шинээр бэлтгэсэн хөрөнгө байхгүй,	90

						батлагдсан 47 орон тооноос 39 орон тоотой ажиллаж байна.																																																					
2.1.3.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.		Батлагдсан 53 465 431.10 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 49524,6 сая төгрөгөөр буюу 104,2 хувиар биелүүлсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын санд 53 465 431.10 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар бүр 83,2-107,4 хувиар биелүүлэн ажилласан, 2024 оны байдлаар нийгмийн даатгалын санд 58898,9 сая төгрөгийн орлого хуримтлуулж орлогын төлөвлөгөөг 106 хувьтай давуулан биелүүлээд байна.	90																																																				
						<table border="1"> <thead> <tr> <th>Сар</th> <th>Төлөвлөгөө</th> <th>Гүйцэтгэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>3,552,27</td><td>2,958,23</td><td>83.2</td></tr> <tr><td>2</td><td>7,289,61</td><td>6,530,37</td><td>90.0</td></tr> <tr><td>3</td><td>12073,28</td><td>11,519,66</td><td>95.4</td></tr> <tr><td>4</td><td>16,150,71</td><td>16,035,00</td><td>99.3</td></tr> <tr><td>5</td><td>20,609,13</td><td>20,731,18</td><td>101.0</td></tr> <tr><td>6</td><td>25,745,61</td><td>25,838,60</td><td>100.4</td></tr> <tr><td>7</td><td>29541,79</td><td>31486,78</td><td>106.6</td></tr> <tr><td>8</td><td>33885,96</td><td>35740,53</td><td>105.5</td></tr> <tr><td>9</td><td>38612,44</td><td>40825,30</td><td>105.7</td></tr> <tr><td>10</td><td>43145,94</td><td>46359,55</td><td>107.4</td></tr> <tr><td>11</td><td>47811,01</td><td>51183,70</td><td>107.1</td></tr> <tr><td>12</td><td>58793,5</td><td>58898,9</td><td>100.2</td></tr> </tbody> </table>	Сар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	1	3,552,27	2,958,23	83.2	2	7,289,61	6,530,37	90.0	3	12073,28	11,519,66	95.4	4	16,150,71	16,035,00	99.3	5	20,609,13	20,731,18	101.0	6	25,745,61	25,838,60	100.4	7	29541,79	31486,78	106.6	8	33885,96	35740,53	105.5	9	38612,44	40825,30	105.7	10	43145,94	46359,55	107.4	11	47811,01	51183,70	107.1	12	58793,5	58898,9	100.2	
Сар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь																																																								
1	3,552,27	2,958,23	83.2																																																								
2	7,289,61	6,530,37	90.0																																																								
3	12073,28	11,519,66	95.4																																																								
4	16,150,71	16,035,00	99.3																																																								
5	20,609,13	20,731,18	101.0																																																								
6	25,745,61	25,838,60	100.4																																																								
7	29541,79	31486,78	106.6																																																								
8	33885,96	35740,53	105.5																																																								
9	38612,44	40825,30	105.7																																																								
10	43145,94	46359,55	107.4																																																								
11	47811,01	51183,70	107.1																																																								
12	58793,5	58898,9	100.2																																																								
2.1.4.	ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.		ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна.	ЭМД-ын сангийн орлого 8288,6 сая төгрөг төвлөрсөн байна.	ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна.	2024 оны байдлаар ажил олгогч, албан журмын даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын санд төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөө 11492712,8 мянган төгрөг батлагдсанаас 11499800,0 мянган төгрөг буюу 100,1 хувиар төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.	93																																																				
2.1.5.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т		Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс - 23.13 хувиар буурсан байна.	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна.	2023 оны жилийн эцсээр нийт 2980,7 сая төгрөгийн авлагатай гарсан. Оны эхний авлагаас 95.0% буюу 2826,9 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнээс үлдэгдэл 153,8 сая төгрөг байгаагаас 112,3 сая төгрөг нь шүүхийн шийдвэртэй гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа авлага, 22,1 сая төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нас барсан, татан буугдсан																																																					

	хүргүүлэх.					байгууллагын авлага бөгөөд үлдсэн 19.1 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулхаар ажиллаж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар урсгал авлага 850,1 сая гарахаар урьдчилсан байдлаар тооцож байна. 2024 онд шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн албанд нийт 12 аж ахуй нэгжийн 118.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг шилжүүлж, 112,1 сая төгрөгийг барагдуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлээ хуулийн хугацаанд төлөөгүй 174 аж ахуй нэгж байгууллагын 1158,5 сая төгрөгт дансны хаалт хийж, 1100,1 сая төгрөгийг татан авсан, Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 15 аж ахуй нэгжийн 97,6 сая төгрөгийн авлага барагдуулах нэхэмжлэл гарган нэхэмжлэлийн шаардлагыг хангуулаад байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах ажилд төр олон нийтийн эрх ашиг хөндөгдсөн, зөрчигдсөн гэж үзэн Хэнтий аймгийн Прокурорын газрын төр төлөөлсөн хяналтын прокуратой 2022 оноос хой байнга хамтран ажиллаж байна.	100
2.1.6.	Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах		Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж өглөг, авлагагүй ажилласан.	Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан бөгөөд 2024 оны жилийн эцэст өглөг үүсгээгүй ажилласан болно.	100
	Бусад өглөг, авлагыг барагдуулах		Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна.	Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна.	а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах. б) Нийгмийн даатгалын	а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд сум тус бүрт өглөг авлагын тайланг хүргүүлэн барагдуулж ажилласан. Бусад өглөг нь ихэвчлэн нийгмийн даатгалын сангуудын данс андуурч хийсэн гүйлгээ сан хооронд өглөг, авлага үүссэнийг залруулж, тайлант хугацаанд бусад	80

2.1.7.					байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах.	өглөг 11.5 сая төгрөг, авлага 60,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан. б) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа оны эхэнд өглөг, авлагагүй гарсан бөгөөд хагас жилийн байдлаар өглөг авлага үүсгээгүй ажилласан болно.																									
2.1.8.	НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.		НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн ерөнхий орлогын дансанд төвлөрсөн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг өдөр бүр НДЕГ-ын төвлөрсөн харилцах дансанд төвлөрүүлсэн. 2024 оны эцэст 58898,9 сая төгрөгийн орлогыг төв санд төвлөрүүлсэн.	100																								
2.1.9.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.		Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 124 675 646.20 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 124.675.646.20 төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.	а/ Нийгмийн даатгалын газраас 2024 онд арилжааны банкуудтай хамтран ажиллах гэрээний дагуу ХААН, Төрийн, Голомт банкинд тэтгэврийн файлыг сар бүрийн ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө хүргэж сар бүрийн эхэн буюу 1-нд тэтгэврийг тавьж олгож хэвшсэн боловч нийгмийн даатгалын системийн нэгдсэн шинэчлэлтэй холбоотойгоор зарим даатгуулагчдын тэтгэврийг жагсаалт хэлбэрээр банкинд хүргүүлэн, олгосон. б/ Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сан тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан. <b>Сангийн зарцуулалт / сая төг/</b>	100																								
						<table border="1"> <thead> <tr> <th>Сан</th> <th>Төлөв лөгөө</th> <th>Гүйцэт гэл</th> <th>Хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Тэтгэвэр</td> <td>113926,4</td> <td>113926,4</td> <td>100</td> </tr> <tr> <td>Тэтгэмж</td> <td>5349,1</td> <td>5349,1</td> <td>100</td> </tr> <tr> <td>ҮОМШӨ</td> <td>5447,6</td> <td>5447,6</td> <td>100</td> </tr> <tr> <td>Ажилгүй дэл</td> <td>1530,5</td> <td>1530,5</td> <td>100</td> </tr> <tr> <td><b>НИЙТ</b></td> <td><b>126253,</b></td> <td><b>126253,</b></td> <td><b>100</b></td> </tr> </tbody> </table>	Сан	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Хувь	Тэтгэвэр	113926,4	113926,4	100	Тэтгэмж	5349,1	5349,1	100	ҮОМШӨ	5447,6	5447,6	100	Ажилгүй дэл	1530,5	1530,5	100	<b>НИЙТ</b>	<b>126253,</b>	<b>126253,</b>	<b>100</b>	
Сан	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Хувь																												
Тэтгэвэр	113926,4	113926,4	100																												
Тэтгэмж	5349,1	5349,1	100																												
ҮОМШӨ	5447,6	5447,6	100																												
Ажилгүй дэл	1530,5	1530,5	100																												
<b>НИЙТ</b>	<b>126253,</b>	<b>126253,</b>	<b>100</b>																												



						6	6	
2.1.10	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.		Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.	Батлагдсан 1288,7 сая төгрөгийн төсвийг зардал ангиллын дагуу 1178,5 сая төгрөг зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	а) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн зардал тус бүрийг хэтрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан ажил үйлчилгээг явуулсан ба 2024 онд шинээр бэлтгэсэн хөрөнгө байхгүй, жилийн эцсийн батлагдсан 47 орон тооноос 39 орон тоотой ажиллаж байна.  б) Байгууллагын үйл ажиллагааны зардалд 1,548.82 сая төгрөг батлагдсанаас цалин хөлсөнд 1,103.15 сая төгрөг нийгмийн даатгалын шимтгэлд 139.40 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.46 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.84 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5.89 сая төгрөгийг, эдийн засгийн ангилал зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, орон тооны дутуутай холбоотой цалин сан хэмнэгдсэн. в) Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой цалин болон нийгмийн даатгалын шимтгэл ХХОАТатварыг тухай бүр шилжүүлж өглөг авлага үүсгэлгүй ажилласан болно.	100	
2.1.11	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах		Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ,	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн	Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн 01-12 сарын мэдээг сар бүрийн 02-ны дотор НДЕГ азарт цахимаар илгээсэн. Дараах мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно. - Сарын мэдээ- 12 удаа		

				сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын сангийн өр авлагын мэдээ- 12 удаа</li> <li>- Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ - 12 удаа</li> <li>- НД-н сангийн санхүүгийн тайлан – 2 удаа</li> <li>- Байгууллагын санхүүгийн тайлан - 2 удаа</li> <li>- Сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан- 2 удаа</li> </ul> <p><b>Э-тайлан</b> - 2 удаа тус тус НДЕГазраас ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь чанартай гаргаж цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан.</p>	100
2.1.12	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.		Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	<p>-Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;</p> <p>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;</p> <p>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор</p>	<p>Нийгмийн даатгалын газар нь үндсэн хөрөнгийн тооллогыг байгууллагын даргын тушаалаар комисс томилж, хагас, бүтэн жилээр тооллогын ажлыг хийдэг. Тооллогоор бүх байцаагч, ажилчдын ашиглаж буй өмч хөрөнгөд хяналтын тооллого хийж, тэдгээрийн эд хөрөнгийг ашиглалтын карттай тулгалт хийн баталгаажуулдаг.</p> <p>2024 оны хагас жилийн тооллогыг 07 дугаар сард хийж холбогдох тайланг гарган тооцоо хийсэн. Жилийн эцсийн тооллогыг газрын даргын А/28 тоот тушаалаар комисс гарган байцаагч ажилчдын эд хөрөнгийн карттай тулган тоолсон. Тооллогоор ямар нэгэн дутагдсан хөрөнгө илрээгүй. Энэ онд 6,4 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг олгодож бүртгэлд тусгасан.</p> <p>Тус газрын эзэмшил газар, барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгийн судалгааг маягтын дагуу гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын <a href="http://burtgel.pcs.gov.mn">burtgel.pcs.gov.mn</a> хуудсанд хугацаанд нь байршуулсан.</p> <p>Тус газрын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант хугацаанд 1 удаа хуралдаж үндсэн хөрөнгийн элэгдлээ</p>	100

				<p>үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;  -Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;  -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;  -Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;  -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн</p>	<p>бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх болон цаашид ашиглах боломжгүй, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах саналыг хэлэлцэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.  Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2023 оны хийсэн ажлын гэрээ дүгнэж тус газар нь 94 хувьтай дүгнүүлсэн.  Түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно.</p>	
--	--	--	--	---	--	--

					түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.		
2.1.13	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.		Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	а/ Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул аймгийн Аудитын газраас ЗӨРЧИЛГҮЙ дүгнэлт авсан болно. б/ Аудитын явцад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үлдэгдлийг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залруулсан. Мөн аудитаар нийт 26.0 сая төгрөгийн албан шаардлага, 0.3 сая төгрөгийн актын төлбөр зөрчил илэрснийг 100 хувь биелэлттэй Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газарт хугацаанд нь хүргүүлсэн.	100
2.1.14	Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх.		Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна.	а/ Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь энэ онд НДЕГазар ХААН, ХАС, ТӨРИЙН, ГОЛОМТ банктай байгуулсан хамтран ажиллах ерөнхий гэрээний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 оны жилийн эцсийн тэтгэвэр олголтын файлыг сарын ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө харилцагч банкнуудад цахимаар хүргүүлэн файл хүлээлцсэн акт үйлдэж сар бүрийн 01-нд тэтгэврийг олгож хэвшээд байна. Банкуудад тэтгэвэр тавьж олгосон үйлчилгээний хөлсийг тарифаар бодож ХААН банкинд 5,9 сая төгрөг, Төрийн банкинд 2,6 сая төгрөг, Голомт банк 0,02	100

						сая төгрөгийг шилжүүлсэн. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэх хугацаа болоогүй байгаа болно.	
2.1.15	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.		Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	а/ Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажиллалаа. б) Шинээр хамрагдсан <b>89</b> аж ахуйн нэгжийн материалыг улсын бүртгэлийн баазтай тулгаж мэдээллийн баазад үнэн зөв бүртгэсэн. Үйл ажиллагаа нь зогссон <b>17</b> аж ахуйн нэгжийн хөдөлгөөнийг мэдээллийн баазад оруулж идэвхгүй хөдөлгөөн хийсэн.	100
2.1.16	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.		ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	“Core” системээр нягтлан бодох бүртгэлийн ажил үйлчилгээг НДЕГ-аас ирсэн заавар, чиглэлийн дагуу тухай бүр хийж гүйцэтгэн гарсан алдаа бүрийг шалган, нягталж хариуцсан дээд албан тушаалтад мэдэгдэн засуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүний нөөцийн green системд байцаагч ажиллагсадын мэдээллийг үнэн зөв бүрэн оруулсан.	100
2.1.17	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах		Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн	а/ Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлангаар өглөг авлага гараагүй бөгөөд харилцагч байгууллагуудтай өр авлагагүй гэсэн тооцоо нийлсэн актыг улирал бүр нийлж баталгаажуулан ажиллаж хэвшсэн. б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар гарсан өглөг, авлагын үлдэгдлийг хариуцсан байцаагч, байгууллага болгонтой улирал	100

					даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	бүр баталгаажуулан ажиллаж хэвшсэн.	
2.1.18	ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх		Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Харилцах дансны үлдэгдэл болон санхүүгийн тайлангаар баталгаажуулсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.	а) ЭМД-ын харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. б) Эрүүл мэндийн даатгалын авлага, өглөгийн тайлангийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан байна. 3903 дансны үлдэгдлийг даатгуулагч тус бүрээр жагсаалт үйлдэж НДЕГ-т ирүүлсэн байна. в) 3303 дансанд бүртгэлтэй ЭМД-ын ташаарсан орлогыг жагсаалт үйлдэж тооцоо нийлж баталгаажуулан НДЕГ-т ирүүлнэ.	а) НДЕГ-ын 2023.12.25-ны 01/2365 албан тоотын дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хааж, 2023 оны жилийн эцсийн үлдэгдэл 660,323.6 төгрөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулсан.  б/ 2024 онд нийт 17,238,823.7 төгрөгийн орлогыг 3303 дансаар бүртгэж, даатгуулагч нэг бүрээр жагсаалт үйлдэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн нийт 17,899,147.3 төгрөгийг төв санд төвлөрүүлсэн.  в/ 3303 дансанд 2023 оны жилийн эцсийн тайлангаар нийт 5,255,511 төгрөгийн илүү төлсөн шимтгэлийн өглөгтэй гарсан бөгөөд даатгуулагч нэг бүрээр жагсаалт үйлдэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулан хүргүүлсэн.	100

**Биелэлт 1753/18 97,3 хувь**

**Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт**

**“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

3.1.1.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих;	-	Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-г 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан.	Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна.	Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг веб сайт хуудсанд бүрэн байршуулах ажил системийн хэмжээнд хангалтгүй үнэлэгдсэн. Засгийн газраас байгууллагын нээлттэй мэдээллийг үнэн зөв, ил тод байршуулсан эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгөх <a href="http://www.shilen.gov.mn">www.shilen.gov.mn</a> цахим хуудсыг нэвтрүүлсэн байна. Тус газар нь дээрх цахим хуудсанд мэдээлэл байршуулан, хяналт тавин ажиллах албан хаагчийг тушаалаар томилон хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Удирдлагын зүгээс Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтад заасан мэдээллийг <a href="http://www.shilen.gov.mn">www.shilen.gov.mn</a> , Нтymна аймгийн албан ёсны вэб сайт <a href="http://www.khentii.mn">www.khentii.mn</a> , нийгмийн даатгалын газрын веб сайтад хуулийн хугацаанд байршуулах, хийсэн ажлын тайланг холбогдох газарт хүргүүлэхийг цахим хуудсанд мэдээлэл байршуулан ажиллах албан хаагчид чиглэл өгч, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаа. Мөн тус газрын хүлээлгийн танхимд байрлах Ил тод нээлттэй мэдээллийн самбар болон ухаалаг дэлгэцэнд холбогдох мэдээллийг тогтмол байршуулсан.	100
3.1.2.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;	-	Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 94.5 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрийн хооронд дотоод аудитын ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, тайлан мэдээ байршуулсан байдал, холбогдох	80

			Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.			шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан эсэхэд үнэлгээ өгч, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан. Шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 139 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 138, хугацаа хоцорч мэдээлсэн 1 мэдээ байна. Нийгмийн даатгалын сантай холбоотой 130 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 124, хугацаа хоцорч мэдээлсэн 6 мэдээ тус тус байна. Энэ нь 1-дүгээр улирлаар 2 мэдээлэл буруу оруулснаас болж засварлах үйлдэл хийсэн тул хугацаа хоцорсон байна. Мөн 3 дугаар улирлын байдлаар хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй боловч нийгмийн даатгалын сангийн 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээг дутуу оруулсан зөрчил гарсныг тухай бүр залруулан ажилласан. 2024 онд НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд улирал бүр хяналт тавих ажлыг Захиргаа, хяналтын хэлтэс, Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэс хамтран хийж гүйцэтгэж байна.	
--	--	--	---	--	--	--	--

**“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж	Шаардл агагүй	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн	Илэрсэн төлбөр зөрчлийн 53 хувийг барагдуулж ажилласан.	Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж	Захиргаа хяналтын хэлтсийн 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг батлан, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.
--	---------------	---	---	--	---



3.2.1.	ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах.		70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана.		холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын хэрэгжилтийг шалгасан. Шалгалтаар 107.3 сая төгрөгийн улсын байцаагчийн акт үйлдэн, 74.1 сая төгрөгийг барагдуулан, 33.2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дархан, Баянмөнх сумын төсөвт байгууллагуудын 2022-2023 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар давхардсан тоогоор 93 даатгуулагчийн 50.4 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод 11.9 сая төгрөгийн шимтгэл ногдуулан хугацаа хэтрүүлсэн хоногт 5.9 сая төгрөгийн алданги тооцон улсын байцаагчийн акт үйлдэн нийт 17.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн 10 байгууллагын албан тоот, хүсэлтийн дагуу улсын байцаагчийн акт үйлдэн нийт 0.87 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснийг төлүүлэхээр шийдвэрлэсэн. Дотоодын хяналт шалгалтын явцад илэрсэн өндөр насны 2 тэтгэвэр авагчийн 7.2 сая төгрөгийн тэтгэвэр илүү	85
--------	---	--	--	--	--	--	----

						олгосон зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.	
3.2.2.	Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх,	Шаард- лагагүй	Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх,	Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. Зохион байгуулсан ажлын хүрээнд 115 хүнтэй холбоотой 5298081 төгрөгийн акт, алданги тогтоогдсон.	Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах	Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын хооронд Хамтран ажиллах санамж бичгийн дагуу Хэнтий аймгийн Дадал сумын хилийн цэргийн 0287 дугаар ангитай байгуулсан санамж бичгийн хүрээнд 2021-2024 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг холбогдох баримтанд үндэслэн шалгасан. Шалгалтаар улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн ажилгүй байгаа эхнэр, нөхөр, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй байгаа цэргийн алба хаагч эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг ирүүлсэн жагсаалтын дагуу шалган үзэхэд 20 даатгуулагчийн төрлийг буруу сонгон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусгасан зөрчил, 2024 оны 07 дугаар сарын 15-ний өдрийн 03/105 тоот албан бичгийн хавсралтын дагуу улсын хил дээр алба хааж байгаа цэргийн алба хаасны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосны дараа цэргийн цолтой ажилласан, 2 цэргийн алба хаагчийг энгийнээр бүртгэсэн зэрэг зөрчил илэрсэн. Тус санамж бичгийн хүрээнд Хилийн цэргийн 0287 дугаар ангийн 20 даатгуулагчтай холбоотой 2814565 төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж, 2 даатгуулагчид холбоотой 1901416 төгрөгийн илүү төлсөн шимтгэлийг дараа сард суутган тооцохоор, илэрсэн зөрчлийг залруулах арга хэмжээ авч ажилласан.	100

3.2.3.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх		21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах,	-	ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах	Монгол улсын засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 420 дугаар тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө”-ний дагуу Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 тоот дугаартай “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан. Шалгалтаар тус газрийн 2021-2023 оны Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн орлого, зарлагын анхан шатны баримтын бүрдэл, хөдөлмөрийн чадвар алдасны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын материалын бүрдлийг мэдээллийн баазтай тулган шалгасан. Шалгалтанд ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авагч 376 хувийн хэрэг, өмнөх онуудад зогсоогдсон болон нас барсан даатгуулагчийн тэтгэврийн хувийн хэрэг хамрагдсан. Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн дүн эцсийн байдлаар шийдвэрлэгдэн ирээгүй байна.	100
3.2.4.	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх		Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин	-	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах	Тус газрын Захиргаа хяналт, шалгалтын хэлтэс нь 2024 оны санхүүгийн жилд Нийгмийн хамгааллын байцаагчгүйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийх төлөвлөгөөнд тусгагдаагүй мөн хийгээгүй болно.	0

			буурсан объектын тоо, хувь				
3.2.5.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах,		Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- ( <a href="http://10.9.0.5/monitoring">http://10.9.0.5/monitoring</a> )-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ.	Цахим хяналтын программд 2023 онд илэрсэн 1701 алдаа байгаагаас тайлант хугацаанд 528 тэтгэвэр, тэтгэмж, шимтгэл төлөлттэй холбоотой алдааг засаж хаасан байна.	Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- ( <a href="http://10.9.0.5/monitoring">http://10.9.0.5/monitoring</a> )-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна.	Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб программ”-аас 2020 онд 7, 2021 онд 105, 2022 онд 42, 2023 онд 96 даатгуулагчийн төрлийг буруу тайлагнасан зөрчил илэрч, 2020-2023 онд нийтдээ давхардсан тоогоор 250 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрсэн. Эдгээр даатгуулагчдыг шалган үзэхэд 44 байгууллагатай холбоотой 50 даатгуулагчийн 786.2 мянган төгрөгийн илүү төлсөн шимтгэл, 2600.1 мянган төгрөгийн дутуу төлсөн шимтгэлийн зөрчил илрүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажилласан. Цахим хяналтын хүрээнд хяналт, шалгалтыг 2023 оныг дуустал хугацаанд сар бүр тогтмол хийж ажилласан. Цахим хяналтын программаар шүүгдэж байгаа нийт алдааны 70 орчим хувь нь зөрчлийн шинжгүй алдаа байгаа бөгөөд шийдвэрлэх боломжтой алдааг анхан шатны баримтад тулгуурлан тухай бүр Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэс, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэстэй хамтран залруулан ажилласан.	90
	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр		Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар		Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр 688 тэтгэвэр тогтоогдсон. Үүнээс өндөр насны 491, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 131, тэжээгчээ алдсаны 66 тэтгэвэр тогтоогдож хянагдсан байна. Мөн шилжиж ирсэн 20 тэтгэвэр, шилжиж явсан 82 тэтгэврийг баазад оруулж мэдээллийн баазын бүрдлийг ханган ажилласан байна. Шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актын дагуу суутгал хийгдэж байгаа 11 тэтгэврийг сар бүр суутгал хийн холбогдох дансанд шилжүүлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгасан, жилийн нэмэгдэл	90

3.2.6.	дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх,		илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ.			<p>хийлгэсэн 510 тэтгэвэр авагчийн мэдээллийг хянан баталгаажуулсан. Тэтгэвэр авах эрхийн харилцаа дууссан нас барсан, зогсоогдсон 517 тэтгэвэр авагчийн олголтын тооцоог хийж хувийн хэргийг хянан архивд шилжүүлсэн байна. НДЕГ-ын даргын 2024.05.29-ний 01/1107 албан бичгийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалган үзсэн. Шалгалтаар 14664 тэтгэвэр, тэтгэмж авагчийн олголтыг шалган үзэхэд 169 тэтгэвэр авагчид 39.9 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрч, 37.3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан барагдуулсан.</p> <p>Дотоодын хяналт шалгалтаар сайн дурын даатгалд хамрагдах гэрээ байгуулан сайн дурын даатгалын шимтгэл төлж байгаа 27 даатгуулагчийн өргөдлийн дагуу гомдол мэдээллийг шалгаж, залруулгын акт үйлдэн, мэдээллийн баазад засвар хийж зөрчлийг арилган ажилласан.</p> <p>Мөн 2022-2023 оны сайн дурын даатгалын хамралт, шимтгэл ногдуулалт, мэдээллийн баазын баяжилт, хуулийн хэрэгжилтийг шалгах дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 онд Хэрлэн суманд хамрагдсан даатгуулагчдын мөнгө төлсөн баримт, харилцахын программ, гэрээтэй тулган шалгахад, алданги дутуу төлсөн болон төлөөгүй 48 даатгуулагчийн 0.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, ажил олгогчтой давхардсан болон алданги илүү төлсөн 7 даатгуулагчийн 0.4 сая төгрөгийг буцаан олгохоор тус тус шийдвэрлэсэн.</p> <p>Тайлант хугацаанд дотоодын хяналт, шалгалтын төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл 38.1 сая төгрөг байсан ба шинээр шалгаж илрүүлсэн 7.2 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж, нийт</p>
--------	--	--	---	--	--	---

						45.4 сая төгрөг болсон. Үүнээс 18.4 сая төгрөгийг барагдуулж, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн байна.	
<b>Биелэлт 645/7 92,1 хувь</b>							
<b>Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.</b>							
<b>“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>							
4.1.1.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх.		Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна	Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын тогтоол 14, Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 15, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал 23, нийт 55 тогтоол, шийдвэрийг хүлээн авснаас хууль тогтоомжийн дагуу 51 албан бичигт хариу хүргүүлэн ажилласан. Мөн дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хүргүүлж, чанартай биелүүлсэн байна.	80
4.1.2.	ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах.		Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна.	Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын байгууллага нь иргэн, даатгуулагч, аж ахуй нэгж байгууллагаас ирсэн санал, өргөдөл гомдлыг бүртгэж холбогдох ажилтан, албан хаагчдад хүлээлгэн өгч хуулийн хугацаанд нь шийдвэрлэхэд хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд нийт 165 өргөдөл, гомдол ирснээс 160 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Үүнээс 5 өргөдөл гомдол хяналтын шатанд хүлээгдэж байна. Мөн орон нутгийн 31-11 “ Иргэд олон нийттэй харилцах төв”-д 3 өргөдөл гомдол ирснийг тухай бүрд хариуг өгч мэдээлэн ажилласан.	85

4.1.3.	Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх.		Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна.	Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн.	Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна.	Иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт болон нөхөн даатгалын лавлагааны хүсэлтийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс able программ, албаны имэйлээр хүлээн авч хариуг ажлын 3 хоногийн дотор гарган өгч хэвшээд байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газарт 562 иргэнээс лавлагааны хүсэлт ирж, 533 иргэн, байгууллагад нийгмийн даатгалын төрөлжсөн архивын лавлагааг олгосон байна. Архивын лавлагаа цахимжиж, аймаг, дүүрэг, сум хооронд Able программ ашиглан ажилласнаар даатгуулагчдад чирэгдэлгүй түргэн шуурхай үйлчилгээ үзүүлдэг.	100
4.1.4.	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах.		Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна.	Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах.	Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/151-р тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлэлгүй ажилласан. 2024 оны жилийн эцсийн байдлаар төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн 5 албан хаагч, төрийн албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр 2 албан хаагчийг тус тус томилсон. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүр Хэнтий аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж хэвшсэн. 2024 оны байдлаар давхардсан тоогоор 16 орон тоог нийтэд ил тод зарласан. Тус газрын албан ёсны facebook хуудас болон Хэнтий аймгийн ЗДТГ-н албан ёсны сайтуудад сул орон тооны зарыг нийтэд тогтмол түгээж байна. Жилийн эцсийн байдлаар тус газарт 8 орон тоо сул байна.	100
4.1.5.	Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил		Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор	Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг	Газрын дотоод ажлыг сайжруулсан,	Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газраас төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын алба	

	<p>зохион байгуулах, тайланг хүргүүлэх</p>		<p>заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.</p>	<p>үүрэг тодорхой болсон байх.</p>	<p>шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ.</p>	<p>хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Асуудлаас-Шийдэлд” болзолт уралдааныг 2024 онд зохион байгуулсан. Тус уралдаанд амжилттай оролцож шийдвэрлэх шатанд шалгарсан 39 төрийн байгууллагаас 3-р байранд шалгарсан. Тус уралдааны хүрээнд 1 ажилтаны нийгмийн асуудлыг сайжруулах ажлын хүрээнд дотоод нөөц бололцоог ашиглан 3,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, иж бүрэн 5 ханатай гэр олгосон. Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран гэр бүлийн хэрэгцээний газаргүй 2 албан хаагчийг дэд бүтэц шийдэгдсэн жишиг хороололд газартай болгосон. Уралдааны хүрээнд төрийн үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай хүргэх зорилгоор нэг ажлыг сайжруулах чиглэл өгөгдсөний дагуу тус газрын архивт хадгалагдаж буй байнга хадгалах 14744 тэтгэврийн хувийн хэргийг тоолж нэгдсэн нэг дугаартай болгон, 380 хайрцагт хийж эмхэлц цэгцэлсэн. Ингэснээр төрөлжсөн архиваас үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээ түргэн шуурхай болсон. Мөн бидний гаргасан санал санаачлагыг аймгийн ЗДТГ-аас дэмжиж 10.2 сая төгрөгийн өртөгтэй ХУРДАН ЦЭГ-ийн иж бүрэн киоск машиныг өгсөн. Тус киоск машиныг газрын хүлээлгийн танхимд байршуулж нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тэтгэвэр авагч ажил олгогчийн тодорхойлолт, нас барсаны лавлагаа, үрчлэлт, төрөлт зэрэг олон төрлийн мэдээллийг иргэд, даатгуулагч нэг цэгээс авах бүрэн боломжтой болсон төдийгүй төрийн бусад байгууллагын ачааллыг хуваалцан ажиллаж, төрийн үйлчилгээг эцсийн хэрэглэгчид шуурхай хүргэж байна. Уралдааны хүрээнд ажил олгогч, иргэд даатгуулагчдад нийгмийн</p>	<p>95</p>
--	--	--	---	------------------------------------	---	--	-----------



						даатгалын үйлчилгээг нэг цэгээс хөнгөн шуурхай цаг алдалгүй хүргэх, ажилтнуудын ая тухтай ажиллуулах зорилгоор газрын 1 давхарт байрлах нэг цэгийн үйлчилгээнд иж бүрэн засвар үйлчилгээг хийж, дулаан алдалтыг багасгаж, гэрэлтүүлгийг нэмэгдүүлсэн. “Асуудлаас-Шийдэлд” уралдааны шагнал 5,0 сая төгрөгөөр ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор албан хаагчдаас санал авсны үндсэн дээр гэрэл, хөшиг авч ажиллах орчноо сайжруулсан.	
4.1.6.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах.		Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна.	Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ.	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна.	ТАХ-ийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан ажиллах орчныг сайжруулах, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зэрэг дэв олгох, ахиулах боломж шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээ судалгааг гарган, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаа. - Төрийн албаны тухай хуулийн хүрээнд 10 байцаагч шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох, 10 байцаагчийн зэрэг дэвийг ахиулахаар холбогдох материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, захирамж гаргуулж нэмэгдлийг зохих ёсоор тооцон олгож байна. Мөн 2024 онд улсын байцаагчийн эрх шинээр авсан 3 байцаагчийн цалингийн шатлалыг ахиулсан. - Мэргэшлийн “Зөвлөх”, зэрэгтэй 9, “Тэргүүлэх” зэрэгтэй 3 байцаагчид тус тус НДЕГ-с ирсэн тушаалын дагуу нэмэгдлийг олгож байна. - Төрийн албаны тухай хууль болон дотоод журамд заасны дагуу 3 албан хаагчид 3,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. - НДЕГазрын даргын тушаалаар мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй 1 албан хаагчид нэмэгдлийг	100

						<p>тооцон олгож байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ахмадуудад Үндэсний уламжлалт Цагаан сарын баяраар 26 ахмадад 1,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.</li> <li>- Газрын даргын Б/23 тушаалыг үндэслэн Орон нутагт тогтвор сууршилтай ажилсан төрийн захиргааны албан хаагчид дэмжлэг үзүүлэх 5 жилийн тэтгэмжийг нийт 17 албан хаагчдад 109.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон.</li> <li>- Мөн цаг үеийн байдалтай холбоотойгоор илүү цагаар ажилласан байцаагч ажиллагсадын илүү цагийн хөлсийг тухай бүр тооцон олгосон.</li> <li>- Хагас бүтэн жилээр албан хаагчдын ажлын үнэлгээг харгалзан мөнгөн урамшууллыг олголоо.</li> <li>- Албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдийн судалгааг шинээр гаргаж “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийг шинэчлэн ажиллаж байна.</li> </ul>	
4.1.7.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх		Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна.	Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах.	Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.	<p>Ажилтан, албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр нийт 5 сургалтанд давхардсан тоогоор 120 албан хаагчдыг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>“Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”</b> цахим сургалтад 2024-03-07нд газрын нийт 25 албан хаагч хамрагдлаа.</li> <li>- Аймгийн Прокурорын газартай хамтран <b>“Гэмт хэрэг зөрчлийн ялгаа”</b>, <b>“Иргэний хэрэгт прокурорын оролцоо”</b> сэдэвт сургалтыг Хэнтий аймгийн Прокурорын газар ахлах прокурор Б.Бямбасүрэн 18 албан хаагч хамрагдсан</li> <li>- <b>“Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх</b></li> </ul>	100

						<p>нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр 2024-10-18нд 28 албан хаагч хамрагдсан</p> <ul style="list-style-type: none"> <li>- <b>“Хориглолт, хязгаарлалт”</b> сэдвээр АЗДТГ-н ТЗУХэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Тэмүүжин 2024-10-24нд 34 албан хаагч хамрагдсан.</li> <li>- <b>Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан соён гэгээрүүлэх өдөрлөгийн арга хэмжээнд 2024-12-10нд 15 албан хаагч хамруулсан.</b></li> </ul> <p>Одоогийн байдлаар авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч байхгүй болно.</p>	
4.1.8.	Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах		НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн “Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам” батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн “Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт” батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна	-	Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг ханган ажилласан байна.	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр 2024 оны 06 дугаар сарын 10-нд “Хамт олон – баг”, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалтуудыг Политехник коллежийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч Ц.Сайханжаргалтай хамтран зохион байгуулсан.</li> <li>- Ажлын байр, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр байгууллагын үйлчилгээний танхимын тохижилтыг сайжруулахаар засварын ажлыг 26,0 төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэж байна. Манай байгууллага нь 2018 оноос хойш урсгал засвар хийгдээгүйгээс хана, тааз, гэрэлтүүлэг, шал, цонх, хаалга шаардлага хангахгүй болсон тул НДЕГазарт засвар үйлчилгээ хийх хэрэгцээ шаардлага байгаа талаар танилцуулж 20,0 сая төгрөгийн санхүүжилтыг шидвэрлэж өгсөн. 12,0 сая төгрөгийг аймгийн ЗДТГазар шийдвэрлэж</li> </ul>	90

					<p>өгсөн. Засварт нэг давхарын үйлчилгээний танхимыг бүхэлд нь шинэчилсэн ба цонх, шал, хаалга, таазыг сольж, харагдах байдлыг сайжруулж гэрэлтүүлгийг нэмж нийгмийн даатгалын ажил үйлчилгээг нэг цэгээс ажил олгогч, иргэд, даатгуулагчдад хөнгөн шуурхай хүргэх таатай орчин, нөхцлийг бий болгон ажилласан.</p> <p>Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөр санхүүжүүлэн 12,0 сая төрөгийн хөрөнгө оруулалт авч НДГазрын дэргэдэх ЭХМКомисын байрны хаалгыг сольж дотор хана таазны засварыг 6,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн мөн НДГазрын үйлчилгээний зааланд 6,0 сая төгрөгөөр “Ухаалаг дэлгэц” авч байрлуулснаар иргэдэд цахим үйлчилгээг тайлбарлан таниулах ажил хийгдэж байна.</p> <p>Аймгийн засаг даргын ивээл дор төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд авилга, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байж үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлаа тодорхойлон шийдвэрлэж, алба хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор зохион байгуулж буй АСУУДЛААС ШИЙДЭЛД тэмцээнд амжилттай оролцож нэг албан хаагчийн нийгмийн баталгааг сайжруулж 3,4 сая төгрөг буюу өөрсдийн нөөц бололцоогоор дутуу баригдсан хашааг шинэ банз авч гүйцээн барьж мөн гэр шинээр барьж хүлээлгэн өгсөн түүнчлэн тухайн тэмцээнд амжилттай оролцон 3-р байранд шалгарсанаар 5,0 сая төгрөгөөр шагнагдаж байгууллагын ажилчдын саналаар бүх өрөөний гэрэлтүүлэг болон хөшгийг сольж орчин нөхцөлийг сайжруулсан байна.</p>
--	--	--	--	--	---

**“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

4.2.1.	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах;		Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо	Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 47 удаагийн сургалтад 1024 албан хаагчийг хамруулсан.	-Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна. -Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газар, “Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар” сургалтад давхардсан тоогоор 840 албан хаагч хамруулсан. Мөн 2024.01.12 ны өдөр НДЕГ-аас зохион байгуулсан “Цахим мэдээллийн цаг”-ийг “Хүн амын орлогын албан татварын тухай хууль, тайлан гаргахад анхаарах асуудал”-ын талаар сургалтад газрын 26 алба хаагч хамрагдсан. 2024.01.19 -ны өдөр “ХАСХОМ мэдүүлэх нь” сэдэвт сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан. 2024.01.22 - ны өдөр Sicos системийн талаарх сургалтад газрын 26 алба хаагчид бүрэн хамрагдсан. 2024.01.29 -ний өдөр Хэнтий аймгийн хяналтын прокурор, хууль цаазын дэд зөвлөх Н.Амгалан “Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулахад анхаарах асуудлууд” сэдвээр газрын албан хаагчдад сургалт, мэдээлэл хүргэлээ. Тус сургалтад газрын 10 албан хаагч болон сумдаас онлайнаар 18 байцаагч оролцсон. 2024.02.20 -ны өдөр “Ажил олгогчийн тайлангийн систем” -ийн танилцуулга сургалтад цахимаар ОШТ-ийн дарга, Орлого шимтгэлийн байцаагч, ХШТ-ийн дарга, Хяналт шалгалтын байцаагч, Үйл ажиллагааны нягтлан, Мэдээллийн технологийн мэргэжилтэн нар хамрагдсан. ХНХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга сургалтад газрын 25 алба хаагч хамрагдсан. 2024.04.08 “Хөдөлмөрийн аюулгүй	100
--------	--	--	---	--	---	---	-----

						<p>байдал- эрүүл ахуйн сарын аян- 2024" хүрээнд хийгдэж буй цахим сургалтад тус газрын 27 алба хаагч хамрагдсан.</p> <p>2024.04.15 "Цахимд хэвшье "DIGITAL FIRST - 01" Сургалтад тус газрын дарга Н.Нямхатан, Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Баярсайхан нар хамрагдсан.</p> <p>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 2024.10.24-25-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 36 албан хаагч хамрагдсан байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.10.24-ны өдрийн 05/2196 албан тоотын дагуу улсын байцаагчийн шалгалтад хамрагдах байцаагчдын сургалтыг 2024.10.28-2024.11.06-ны өдрүүдэд зохион байгуулсанд нийт 10 байцаагч хамруулаа.</p> <p>"Гамшгийн үед авах арга хэмжээ" сургалтыг 2024.11.01-ны өдөр НДЕГ-с цахимаар нийт 35 албан хаагч хамрагдсан.</p> <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, манлайллыг дэмжих, ёс зүй төрийн албыг бэхжүүлэх сургалтыг 2024.11.07-ны өдөр 25 албан хаагчид хамруулсан.</p> <p>Гамшгаас урьдчилан сэргийлэх нь сургалтыг Аймгийн Онцгой байдлын газраас төвийн нийт 13 албан хаагч, Сумын 16 албан хаагчдыг ZOOM-хамруулсан байна.</p>	
4.2.2.	Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын		Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 288 удаагийн сургалтад 17522 иргэд, даатгуулагчийг хамруулсан.	Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.	Нийтдээ 244 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 19630 иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт, мэдээлэл хүргэн ажилласан.Үүнд:	

	даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах;					Аж ахуй нэгж байгууллага, албан журмын даатгуулагчдад чиглэсэн сургалтын хүрээнд 126 удаагийн сургалтаар 9902 даатгуулагчийг сургалтад хамруулсан.  Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, ажилгүй иргэдийн сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 118 удаагийн сургалтаар 9728 даатгуулагчийг хамруулсан байна.	90
4.2.3.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;		Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид,	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 130 тоо, мэдээллийн төрөл 5	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна.	Тайлант хугацаанд тус газар нь өөрийн цахим хуудас <a href="http://www.hentii.ndaatgal.mn">www.hentii.ndaatgal.mn</a> вэб сайт, <a href="http://www.facebook.com/NDKHenti">www.facebook.com/NDKHenti</a> фэйсбүүк, “Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар” фэйж хуудсаар 111 мэдээлэл, постер оруулж мөн ХНХЯам, НДЕГ-аас бэлтгэсэн сурталчилгаа, мэдээ, мэдээллийг цахим сүлжээ ашиглан олон нийтэд түгээсэн ба давхардсан тоогоор 256 мянга гаруй иргэд даатгуулагчдад хүрсэн байна. Сайн дурын даатгуулагчдад зориулсан “Та шимтгэлээ төлсөн үү” гэх шимтгэл төлөх заавартай постерийг сар бүр цахим орчинд байршуулж хэвшсэн. “Аруухан” фэйж хуудастай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээний дагуу 2 шторк, 6 мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтэд хүргэн ажилласан. Нээлттэй мэдээллийн сарын хүрээнд - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль - Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль - Сайн дурын даатгалын талаар 3 удаагийн live дамжуулалт хийж хийт 36 мянган хүний хандалт авсан байна. Мөн “Мэдлэгтэй чихэр” хуулийн тухай контентыг бэлтгэн цахим орчинд байршуулсанаар 2,7 мянган хүний хандалт авсан.	90

			зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл			Цахим хуудас болон албан хаагчдыг идэвхижүүлэх зорилгоор “Бурмаар тэтгэхээр, Урмаар тэтгэ”, “Дэм дэмдээ” зэрэг контентуудыг хийж гүйцэтгэсэн байна.	
--	--	--	---	--	--	---	--

**“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

4.3.1.	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах		Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад жилд 4-өөс доошгүй удаа хяналт хийсэн байна.	Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгаан шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад хяналт хийж холбогдох арга хэмжээ авсан байна.	Хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд эрүүл мэндийн үзүүлэлттэй харьцуулан дүн шинжилгээ хийхэд өмнөх жилийнхээс өвчлөл ихэссэн байна. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг 2023 оны 12 сарын шинэчилсэн жагсаалтыг үндэслэн сунгалтанд орсон 2261 иргэдэд дахин хувь хугацаа заалтыг шинэчлэн өөрчилж оношийн баталгаажилтыг 5 удаа хийж холбогдох сумдын эрхлэгч болон эмч нарыг оролцуулан цахим зөвөлгөөг 3 удаа өгсөн.	85
			Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд хагас жил тутам тулгалт хийсэн байна.		Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлтэд жилд 2 –оос доошгүй удаа тулгалт хийж зөрчил дутагдлыг тухай бүр арилгах арга хэмжээ авч ажилласан байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санд 2 удаа тулгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилган ажиллалаа. /хөдөлмөр халамж үлчилгээний газар, нийгмийн даатгалын газрын/ Тайлант хугацааны жилд Улаанбаатарын харъяатай 2 иргэнийг Баянзүрх дүүрэг, Налайх дүүрэгт тус тус шилжүүлсэн. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээллийн санд 2 дахь удаагийн тулгалтаар хугацаагүй заалттай иргэдээс харъяалалын дагуу зөрчилтэй 13 иргэнийг шалгаж шилжүүлэв. Харъяа газрын магадлагч эмч болон ах дүү өөртэй нь холбоо тогтоосон. Мөн	



						хугацаатай заалттай иргэдээс 2 хүнийг шилжүүлэв.	
4.3.2.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах арга хэмжээ зохион байгуулсан байх		Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг хагас жил тутам зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	Зохион байгуулсан ажлын тоо, тайланг ЭММТЗ-д хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	ЭММЗөвлөлийн хурлаар дотоод үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж 2071 иргэний картанд хяналт шалгалт хийсэн. Иргэдийн картанд үзлэг, шинжилгээ, хяналт дутуу гэсэн зөрчилтэй 68 иргэнийг илрүүлж дутуу үзлэг, хяналт шинжилгээнд буцаасан ба дахин шалгах шаардлагатай 10 иргэнийг өөрийн биеэр дараагийн хуралд ирүүлж асуудлыг шийдвэрлэсэн.	90
			Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна.		Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, ижил мэргэжилтний үзлэгийг зохион байгуулж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадвар сайжирч иргэний	ЭММЗөвлөлийн эмч нартайгаа хамтарч дотоод хяналтыг эрчимжүүлэх зорилгоор иргэдийн ирсэн сунгалтын картанд хяналтыг 7 хоног бүрийн 3 дахь өдрийн хурлаар хамтран хийж зөвөлгөө өгөх ба цахим мэдээлэлээр дамжуулан мэдээ мэдээлэлийг өгч байна. ЭММТЗөвлөлөөс 2024 онд даатгуулагч, хүний ХЧАлдалтын хувь хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсалтын дагуу мэргэжлын багаас бүрдсэн эмч нарын сургалтыг цахимаар 6 удаа хийж сургалтанд хурлын 5 эмч 3	

					хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үйл ажиллагаа ижил түвшинд хүрсэн байна.	мэргэжилтэн 6 удаа оролцсон зэргээр мэргэжилтнүүдийн мэдлэгийг сайжруулах тал дээр анхаарч ажилласан. Эмчлэн эдгэрүүлэх төлөвлөгөө боловсруулж, Сэргээн засах тасгийн эрхлэгч Хатанбаатар эмчтэй хамтран ажиллаж Физик эмчилгээнд илүүтэй хамруулан эмчилгээнд бариа заслаас гадна зүү төөнүүр, хөдөлгөөн засал, татлага эмчилгээний төрлүүдийг нэмэгдүүлж ажилласан нь үр дүнгээ өгч байгаа бөгөөд одоогийн байдлаар 458 гаруй иргэдийг уламжлалт үзлэгт хамруулж 78 иргэнийг хэвтэн эмчлүүлээд байна.	
4.3.3.	Эрүүл мэндийн магадлалын оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн хэрэгжилтийг ханган ажиллах		Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах жилийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэн ажиллана.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн болон судалгааны тайланг ЭММТЗ-д хүргүүлнэ.	Хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэж Хөдөлмөрийн чадвар алдалттай бүх иргэдийн судалгаа мөн төлөвлөгөөг сум, өвчлөл бүрээр гаргаж өвчлөлийн дагуу эмчлэн эрүүлжүүлэх төлөвлөгөө мөн дахин өөр өвчинд өртөх болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах талаар зөвлөгөө өгч ажиллаж байна. Сунгалтанд хурлаар орж ирэх үед нь шалгаж бас зөвлөгөө өгч ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт хэрэгжилтийг хагас бүтэн жилээр нь ЭММТЗөвлөлд хүргүүлж ажилласан Хөдөлмөрийн чадвар алдалтын суурь судалгааг өмнөх жилийн эцсийн байдалтай харьцуулсан гаргасан.Бүх сумдын хүн амын тоонд харьцуулан гаргаж мөн өвчлөл тус бүрээр, шинээр орсон иргэдийн судалгааг өвчлөлөөр нь тус тусад нь гаргаж хурлын гишүүд болон холбогдох эмч нарт танилцуулж ажилласан. Гишүүд эмч нар өөрсдийн хариуцсан сум мөн мэргэжлийн өвлөлийн дагуу судалгааг хийж гаргаж дүгнэлт өгч ярилцлага зохион байгуулж ажиллалаа. Ярилцлагаар 2023 онд шинээр батлагдсан өвчний жагсаалтын нэр заалт, ихэссэн мөн өвчлөл	90

						ихэссэнтэй холбоотой Хөдөлмөрийн чадвар алдтын тоо ихэссэн байна гэдэг дүгнэлтэнд хүрсэн.	
			Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгаа хийж, тодорхой арга хэмжээ авч орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагад танилцуулсан байна.		Орон нутгийн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд суурь болон харьцуулсан судалгааг хийж дүгнэсэн байна.		
4.3.4.	Эрүүл мэндийн магадлалын талаарх хууль тогтоомжийн талаар болон авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах		Төрөлжсөн мэргэшлийн болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийн талаар болон	Зохион байгуулсан сургалтын тоо 5, хамрагдсан хүний тоо, тайланг хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн болон төрөлжсөн мэргэшлийн, сум, өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн магадлалтай	“Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны А/441, А/192-р тушаал, “Журам, маягтын загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан	80

			<p>авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна.</p>	<p>холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулж шинэ мэдээ, мэдээллийг хүргүүлж ажилласан байна.</p>	<p>2023 оны А/177 А/443-р тушаал, Засгийн газрын 2023 оны 448-р тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж ЭМГазартай хамтарч 15 сумын 40 эмч мэргэжилтнүүдэд сургалтыг зохион байгуулж ажилласан.</p> <p>ЭММЗөвлөлийн гишүүд болон сум өрхийн эмч нарт авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан.ЭММЗөвлөлөөс авилга ашиг сонирхлын талаар мэдээлэл сургалтыг хийсэн ЭММЗөвлөлийн гишүүн 5 эмч 3 мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдлын сарын аяны хугацаанд урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нэгдсэн эмнэлгийн ажилчид, сумдын эрүүл мэндийн ажилчид, эвт худалдааны төвийн ажилчдад болон ХБИргэдэд сургалт мэдээлэл өгч сургалтын материалыг тарааж ажилласан.</p> <p>Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Хүний эрхийн хороотой хамтарч төрийн байгууллагын ХАБ хариуцсан мэргэжилтнүүдэд иргэдийн танхимд болон халамж үйлчилгээний төвд сургалт зохион байгуулж арга зүйн зөвөлгөө өгч ажилласан Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал шийдвэрлүүлэх зүүн бүсийн уулзалтад оролцож “Хэнтий аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өнөөгийн байдал”-ын талаар төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 48 төлөөлөлд мэдээ, мэдээллийг хүргэсэн. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн</p>
--	--	--	--	--	--

						<p>бичгийн даргын 2024 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/15 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхжуулах нь” сэдэвт бүсчилсэн</p> <p>Зүүн бүсийн сургалтанд 2024 оны 10 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд Дорнод аймагт 2 эмч, халамжийн мэргэжилтэний хамт амжилттай оролцсон.</p>	
--	--	--	--	--	--	--	--

*“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*

4.4.1.	Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх		Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна.	2024 оны 01 дүгээр сарын 01-ээс Сикос шинэ системийг нэвтрүүлснээр иргэн, ААН байгууллагын мэдээллийг хур системээс татдаг болсон тул мэдээлэл зөрүүтэй даатгуулагч засварлах, регистр нэгтгэх, зөрөх тохиолдол гарахгүй болсон.	100
			Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх		<ul style="list-style-type: none"> <li>- Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.</li> <li>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.</li> <li>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.</li> <li>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв</li> </ul>		

					хүлээн авсан байна.		
			Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх		Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна.		
4.4.2.	Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх		Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх	Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан.	Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.	<p>“Сикос” шинэ системийг нэвтрүүлээд үйл ажиллагаандаа ашиглаж байна. Систем хөгжүүлэлт бүрэн хийгдэж дуусаагүй өөрчлөлт шинэчлэлтүүд хийгдэж байгаа цаг тухай бүр үйл ажиллагаандаа өөрчлөлт шинэчлэлтийг хийж ажиллаж байна.</p> <p>Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардсан тохиолдлыг тухай бүр засварлаж ажиллаж байна.</p> <p>Систем автоматаар ноогдуулалт хийж байгаа тул төлөлтөөс хэтрүүлж ноогдуулалт хийгдэхгүй байгаа</p>	100
			Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх		Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна.		
			Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй		Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна.		

			байх				
4.4.3.	Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах		Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах		Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.	<p>Тус газрын нэг цэгийн үйлчилгээнд шинээр 65 инчийн мэдрэгчтэй дэлгэцийг байршуулсан. Тус дэлгэцнээ нийт албан хаагчдын мэдээлэл холбоо барих утасны дугаарыг харах, нийгмийн даатгалын цахим систем буюу <a href="https://portal.ndaatgal.mn/#/landing">https://portal.ndaatgal.mn/#/landing</a> рүү хандаж АО-ын тайлан, СДД-ын гэрээ, Тэтгэмжийн хүсэлтүүд илгээх боломжтой болсон.</p> <p>Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран “Хурдан” киоск машиныг байршуулснаар иргэд даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, иргэн, хуулийн этгээд гэх мэт нийт 18 төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болсон байна.</p> <p>Дохиолол хамгааллын тоног төхөөрөмжүүдийг шинээр суурилуулсан. Үүнд: Дохиоллын станц, мэдээ дамжуулагч, дуут дохиологч, NVR бичигч 1, 16 порттой свич 1, гадна камер 4, дотор камер 7, утаа мэдрэгч 18, хөдөлгөөн мэдрэгч 10 ширхгийг байршуулсан.</p> <p>Газрын байранд сервер 1, router 1, wifi router 2, switch 7, kiosk төхөөрөмж 1, компьютер, принтерийг нийгмийн даатгалын газарт 18 ширхэг, сумдад 22 ширхгийг ашиглаж байна. Өдөр тутамдаа сервер, дотоод сүлжээний төхөөрөмжүүд, компьютер, хэвлэгч төхөөрөмжүүдийн хэвийн байдлыг шалгаж доголдол гарсан тохиолдол түргэн шуурхай хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын</p>	100

						даргын 2015.12.07-ны өдөр баталсан “Сервер компьютерт оны эцсийн үйлчилгээ хийх журам” -ын дагуу 2024.02.15-ны өдөр хуваарьт хугацаандаа мэдээллийн технологийн төвөөр оны эцсийн үйлчилгээг хийлгэж, үйлчилгээний тойрох хуудсыг хөтөлж мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн.	
			МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх		МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна.		

**Биелэлт 1675 / 18 93 хувь**

**Тав. Бусад ажил үйлчилгээ**

5.1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж мод тарина		Тарьсан модыг арчилж ургуулсан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж нийт 138 мод тарьсан.	Өмнөх тарьсан модоо сэргээж, нөхөн сэргээлт хийх.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж энэ онд нийт 25 мод нийтийн эзэмшил, хувийн хашаа, цэцэрлэгт хүрээлэн гэсэн газруудад тарьсан. 2024 оны 05 дугаар сарын 11-нд хаиуцсан цэцэрлэгт хүрээлэнд 10 ширхэг голт бор мод суулгаж ирүүлсэн чиглэлийн дагуу самбар байршуулж тарьсан модоо байнга арчлан услаж байна. Мөн хашаанд амьдардаг албан хаагчид хашаандаа жимсний 25 ширхэг мод тарьсан.	100
	Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах талаарх		Зохион байгуулсан ажлын тоо		Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхдийн	Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийгмээрээ үл тэвчих, хүүхдэд бие махбод, сэтгэл санааны шийтгэл оногдуулах явдлыг таслан зогсоохын чухалыг олон нийтээр хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор жил бүрийн 04 дүгээр сарын 30-ны өдрийг “Хүүхдийг	



5.2.	сургалт, ажил үйлчилгээ зохион байгуулах				аюулгүй байдлыг хамгаалах талаарх сургалт, ажил үйлчилгээ зохион байгуулах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна.	зодож шийтгэхийг таслан зогсоох олон улсын өдөр” болгон Хүүхдийн эрхийн тухай Конвенцод нэгдсэн улс орнууд 1998 оноос тэмдэглэж ирсэн. Уг өдрийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдад “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сургалтыг Сан хариуцсан мэргэжилтэн Д.Болор-Эрдэнэ / Эцэг эхийн зөвлөлийн дарга / “ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ХҮМҮҮЖИЛ БА ЭЦЭГ ЭХИЙН НӨЛӨӨЛӨЛ” сэдвээр мэдээлэл хүргэж, Баянхутаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн зураг зүйн багш М.Алтанзул хүрэлцэн ирж “Жаргалтай өдөр” уриан дор хүүхэд багачууд эцэг эхтэйгээ хамтран зураг зурж өнгөрүүлсэн.	100
5.3	Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчлэн найруулга/ батлагдан 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой 7 хоног бүрийн 1 өдөр шинэ хууль, дүрэм, журамтай холбоотой мэдээлэл, сургалтыг тогтмол хийх		7 хоногт 1 удаа мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хэвшсэн байх	Шинэ хэрэгжих	Сар бүрийн эхэнд төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулан сургалтыг зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг бүх шатны байцаагч, албан хаагчид нэг мөр ойгож хэрэгжүүлэн ажиллана.	Нийгмийн даатгалын ерөнхий хууль шинэчилэгдсэнтэй холбоотой гарч байгаа дүрэм, журам, зааварыг нэг мөр ойлгох үүднээс долоо хоног бүрийн 5 дахь өдөр болгон байцаагч, албан хаагчдад мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаж байна.	100
<b>Биелэлт 300/3 100 хувь</b>							
<b>Нийт үнэлгээ 479/5 95,8 %</b>							

Тайланг хянасан:

**Төсвийн төвлөрүүлэн захирагч**

ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал)  
Тэмдэг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
.....  
(гарын үсэг)

/Ц.ГАНЦЭЦЭГ/

(огноо)

*Төлөвлөгөө тайлагнасан:*

**Төсвийн Шууд захирагч**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА  
(албан тушаал)  
Тэмдэг

.....  
(гарын үсэг)

/Н.НЯМХАТАН/

(огноо)

